

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь МЦРМ202203598 дугаар бүхий Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Баргилт орд Баргилт хайгуулын талбайд хийгдэх нэмэлт хайгуул ажил зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших MV-016657 тоот “Баргилт” орд, XV-021822 тоот Баргилт хайгуулын талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр цайрын нөөцийн тодотгол тайлан, жоншны нөөцийн тайлан бичиж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Бор-Өндөр” УБҮ-ийн цайрын хүдрийн нөөц, жоншны хүдрийн нөөцийг батлуулах, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ.
Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойших байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл үйлчлүүлэлгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 25–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 28– ны өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ